



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

**Барилга байгууламжууд акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Хан-Уул дүүргийн 49 дүгээр цэцэрлэгийн баланст бүртгэлтэй, нийт 202,239,923.16 (хоёр зуун хоёр сая хоёр зуун гучин есөн мянга есөн зуун хорин гурван төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжуудыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН

1110100286

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
89 дүгээр тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2022.08.30/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Цэцэрлэгийн барилга -1	1963	67,168,381.20	31,485,178.69	35,683,202.51	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2022 оны 02-07-395/848 дугаар дүгнэлт
2	Цэцэрлэгийн барилга -2	1976	78,362,598.96	41,979,963.73	36,382,635.23	
3	Склад /агуулах/	1963	3,024,000.00	2,948,397.98	75,602.02	
4	Шугам сүлжээ	1963	34,665,700.00	27,168,250.00	7,527,450.00	
5	Нийтийн эзэмшлийн хөрөнгө	1963	19,019,243	11,128,111.31	7,891,131.69	
НИЙТ ДҮН			202,239,923.16	114,679,901.71	87,560,021.45	